



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/127

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын цар тахал (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн зам талбайд халдваргүйтгэл хийх зардалд 12.405.600 (арван хоёр сая дөрвөн зуун таван мянга зургаан зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 12.405.600 (арван хоёр сая дөрвөн зуун таван мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100277

Аймгийн Засаг даргын 2020 оны 03  
дугаар сарын 25-ны өдрийн 111 дугаар  
захирамжийн хавсралт

**АРВАЙХЭЭР СУМЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ, ТАЛБАЙ  
ОРОН СУУЦНЫ ОРЦ, ГРАЖ, ХОГИЙН ЦЭГТ ХАЛДВАРГУЙТГЭЛ,  
ХИЙХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Хүн хүчний судалгаа:

| № | Байгууллагын нэр            | Ажиллах хүн | Нийт ажиллах хүн |
|---|-----------------------------|-------------|------------------|
| 1 | Зоонозын өвчин судлалын төв | 10          | 10               |

Нийт хамгаалах хувцас, хэрэгсэлийн тооцоо /5 өдөр/

| №        | Нэрс  | Нэг бүрийн үнэ | Нийт ажиллах хүний тоо | Нийт ажиллах хоног | 1 өдөрт | Нийт үнэ  |
|----------|---|----------------|------------------------|--------------------|---------|-----------|
| 1        | Амны хаалт 1 удаа                           | 800            | 10                     | 5                  | 200     | 160000    |
| 2        | Комбинзон                                   | 27000          | 10                     | 5                  | 50      | 1350000   |
| 3        | Нүдний шил                                  | 20000          | 10                     | 5                  | 10      | 200000    |
| 4        | Амны хаалт №95                              | 10000          | 10                     | 5                  | 20      | 200000    |
| 5        | Нэг удаагийн малгай                         | 300            | 10                     | 5                  | 100     | 30000     |
| 6        | Бээлий                                      | 250            | 10                     | 5                  | 100     | 25000     |
| 7        | Нэг удаагийн халад /дотор талдаа гялгартай/ | 3000           | 10                     | 5                  | 50      | 150000    |
| 8        | Улавч                                       | 200            | 10                     | 5                  | 150     | 30000     |
| Нийт дүн |   |                |                        |                    |         | 2.145.000 |

Халдваргүйтгэлийн бодис /1 өдөр/

| №        | Бодисын нэр   | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ   |
|----------|---|------------|----------------|------------|
| 1        | Жавелион /халдваргүйтгэлийн бодис/                          | 138        | 72000          | 9.936.000  |
| 2        | Спиртэн суурьтай гар халдваргүйтгэлийн бодис санитол 1 литр | 3          | 20000          | 60.000     |
| 3        | Уураар халдваргүйжүүлэхэд хэрэглэх бензин                   | 60 л       | 1890           | 113.400    |
| 4        | Уураар халдваргүйжүүлэхэд явах авто машины шатахуун         | 80 л       | 1890           | 151.200    |
| Нийт дүн |   |            |                | 10.260.600 |

Нийт гарах зардлын тооцоо

| №        | Зардлын төрөл                     | Нийт зардал /мян.төгрөгөөр/ |
|----------|-----------------------------------|-----------------------------|
| 1        | Хамгаалах хувцас хэрэгсэл         | 2.145.000                   |
| 2        | Халдваргүйтгэлийн бодис, шатахуун | 10.260.600                  |
| Нийт дүн |                                   | 12.405.600                  |